



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/64

Өлгий

Г Ажлын хэсэг байгуулах тухай 7

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5, 58 дугаар зүйлийн 58.1.1 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам” батлах тухай 03 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 1а/3266 дугаар “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хүрээнд байгууллагын бүтэц, орон тоо, чиг үүргийг оновчтой болгох, албан тушаалтнуудын гүйцэтгэх ажлын давхардлыг арилгах, албан тушаалтнуудын ажил, үүрэгт чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

- Хяналт шалгалтын хэлтсийн Эмчилгээний чанарын хяналтын улсын ахлах байцаагч О.Лхагважав,

Гишүүд:

- Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн Эрүүл мэндийг дэмжих, салбар хоорондын хамтын ажиллагаа, байгууллагын дотоод ажил хариуцсан ажилтан Ш.Аманбол,
- Удирдлага төлөвлөлт, санхүү, хяналт-шинжилгээ, мэдээллийн хэлтсийн Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт, мэргэжлийн зөвшөөрөл, эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал хариуцсан мэргэжилтэн Б.Нуржайнар

Ажлын байрны шинжилгээ хийх үйл ажиллагааг зохион байгуулж, албан тушаалтнуудын гүйцэтгэх ажил, үүргийн хуваарилалт, чиг үүргийн уялдаа холбоог тодорхойлох, давхардал, хийдэл болон шаардлагагүй чиг үүргийг илрүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээний санал дүгнэлт боловсруулан дүнг нэгтгэн, удирдлагад танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (О.Лхагважав)-д үүрэг болгосугай.

Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангуулах, ажлын хэсгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхийг холбогдох хэлтсийн ахлах мэргэжилтнүүдэд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ДАУЫРЖАН



